

## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

**Байршил:** Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

**Эхлэх хугацаа:** 2025/05/05 **Дуусах хугацаа:** 2025/05/16

**Ажил эхлэх хугацаа:** 2025/05 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

## НЯРАВ

(Түр ажлын байр)

### *Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:*

- Байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн орлого, зарлагын анхан шатны бүрдүүлэлтийг хийх, орлого, зарлагын гүйлгээ хийх
- Санхүүгийн гүйлгээний анхан шатны баримт материалыг хөтлөх
- Бараа хүлээн авах, ачуулах ажлыг зохион байгуулах, хянах, холбогдох бүртгэлийг хөтлөх
- Нөөцийн бүртгэл хөтлөх, бараа бүтээгдэхүүний олголтод хяналт тавих, эрэлт хэрэгцээг тодорхойлж захиалга хийх
- Шаардлагатай үед ажлын байрны тодорхойлолтод дурдагдаагүй бусад ажил үүргийг гүйцэтгэх

### *Тавигдах шаардлага:*

- Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Компьютерийн өргөн хэрэглээний програмууд болон санхүү бүртгэлийн програм дээр ажиллах чадвартай байх;
- Багаар болон бие даан ачаалал дааж ажиллах чадвартай байх;
- Үнэнч шударга, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй байх;
- Англи хэлний А2 болон түүнээс дээш түвшний мэдлэгтэй байх.

### *Бүрдүүлэх материал:*

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар – CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

### *Холбоо барих:*

Та баримт бичгээ англи, монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж [recruitment@gmit.edu.mn](mailto:recruitment@gmit.edu.mn) хаягаар бидэнд ирүүлнэ үү.

**Цахим хуудас:** [www.gmit.edu.mn](http://www.gmit.edu.mn)

**Утас:** +976-7023 2090

**Жич:** Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярицлагад урих болно.